



Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2020 оны 02 сарын 11-ны
өдрийн 1702 дугаарт бүртгэв.

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 12 сарын 30 өдөр

Дугаар А/269

Улаанбаатар хот.


Маягтын загвар батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.2, Татварын ерөнхий хуулийн 77 дугаар зүйлийн 77.7.3, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Бичил худалдаа, ажил, үйлчилгээ эрхлэгч хувь хүний албан татвар төлсөн гэрчилгээний маягтын загвар"-ыг 1 дүгээр, "Гэрчилгээг хэрэглэх заавар"-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтийг хангаж, хавсралтаар батлагдсан маягтыг цахим татварын системд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Татварын орлогын газар /Д.Цогтжаргал/, Мэдээллийн технологи, статистикийн төв /Х.Батбаяр/-д тус тус даалгасугай.

ДАРГА



Б.ЗАЯАБАЛ

Бүртгэлийн дугаар 08


ТАТВАРЫН ЕРӨНХИЙ
ГАЗАР

ХУУЛБАР ҮНЭН

Хуулбар олгосон ажилтны гарын үсэг

20... оны ... сарын ... -ний өдөр

2019. Татварын ерөнхий газрын даргын
оны 12 сарын 20 өдрийн дугаар
тушаалын 1 дүгээр хавсралт



ТЕГ-ын даргын 2020 оны ... тоот
тушаалын ... дугаар хавсралт

АЛБАН ТАТВАР ТӨЛСӨН ГЭРЧИЛГЭЭ
№ ...

Бичил худалдаа, ажил, үйлчилгээ,
хувиараа эрхлэгч татвар төлөгч хувь хүн

1. Овог:
2. Нэр:
3. ТТД:
4. Бичил худалдаа ажил үйлчилгээний төрөл:
 - 4.1. Худалдаа, ажил, үйлчилгээ;
 - 4.2. Зорчигч, ачаа тээврийн үйлчилгээ;
5. Гэрчилгээ олгосон: аймаг(нийслэл).....
сум(дүүрсэг).....
6. Татвар хураасан ТТД:
7. Гэрчилгээний хүчинтэй хугацаа(сараар):

	Он	Сар	Өдөр
Эхлэх			
Дуусах			
Хугацаа			

8. Төлсөн татварын дүн:
9. Огноо:



Албан татвараа хуулийн хугацаанд төлсөн
ТАТВАР ТӨЛӨГЧ ТАНД БАЯРЛАЛАА.

Эх сурвалж: <http://itax.mta.mn>
www.e-tax.mta.mn

Бүртгэлийн дугаар 08
ТАТВАРЫН ЕРӨНХИЙ
ГАЗАР
ХУУЛБАР ҮНЭН
Хуулбар олгосон ажилтны гарын үсэг
20... оны ... сарын ... -ний өдөр

Татварын ерөнхий газрын даргын
2019 оны 02 сарын 29 өдрийн 02 дугаар
тушаалын 02 дугаар хавсралт

“АЛБАН ТАТВАР ТӨЛСӨН ГЭРЧИЛГЭЭ”-Г ХЭРЭГЛЭХ ЗААВАР

1.Татварын алба нь Хувь хүний орлогын албан татварын хуулийн 26.2-т заасны дагуу бичил худалдаа эрхлэгч, ажил, үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг олгох орон нутгийн засаг захиргааны нэгжийн холбогдох албан тушаалтанд татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангаас татвар төлөгчийн дугаараар цахим төлбөрийн баримтыг үүсгэх, албан татвар төлөгчийн албан татвар төлсөн гэрчилгээг хэвлэн албан татвар төлөгчид олгох боломжийг хангана.

2.Татварын алба нь бичил худалдаа, ажил, үйлчилгээ эрхлэгчийн татварын орлогыг төвлөрүүлэх дансыг холбогдох төсвийн ангиллын дагуу төрийн санд байршуулна.

3.Татвар төлөгч нь албан татвар төлөгчийн гэрчилгээг татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангаас хэвлэн авах боломжтой байна.

4.Хэвлэмэл маягт дараах мэдээллийг агуулна:

Гэрчилгээний дугаар

- 4.1.бичил худалдаа, ажил үйлчилгээ эрхлэгч хувь хүний овог;
- 4.2.албан татвар төлөгчийн нэр;
- 4.3.албан татвар төлөгчийн дугаар;
- 4.4.бичил худалдаа, ажил, үйлчилгээний төрөл:
 - 4.4.1.худалдаа, ажил, үйлчилгээ;
 - 4.4.2.зорчигч, ачаа тээврийн үйлчилгээ.
- 4.5.гэрчилгээ олгосон аймаг (нийслэл). . . ., сумын (дүүрэг) нэр;
- 4.6.татвар хураасан ТТД;
- 4.7.гэрчилгээний хүчинтэй хугацаа;
- 4.8.төлсөн татварын дүн;
- 4.9.огноо.

5.Хувь хүний орлогын албан татварын хуулийн 27.3-т заасны дагуу бичил худалдаа, ажил, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох эрх бүхий орон нутгийн засаг захиргааны нэгж нь албан татварын тайланг харьяа татварын албанд дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлж, тооцоо нийлнэ.

6.Бичил худалдаа, ажил, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл эзэмшигч нь Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасны дагуу худалдаа, ажил үйлчилгээ, зорчигч, ачаа тээвэр хийх тухай бүр хувь хүн, хуулийн этгээдэд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй.

7.Харьяалах татварын алба бичил худалдаа, ажил, үйлчилгээ эрхлэгч хувь хүний татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавьж хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

Бүртгэлийн дугаар 08

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ
ГАЗАР

ХУУЛБАР ҮНЭН

Хуулбар олгосон татварын гарын үсэг

20 01 06

20... оны ... сарын ... -ний өдөр